



- Гялгар уут хэрэглэхгүй байх
- Эко анги шалгаруулах.
- Байгаль хамгаалах аян өрнүүлэх.

#### **Дөрөвдүгээр алхам : Хяналт үнэлгээ:**

Үнэлгээний хувьд манай удирдлагууд улиралаар дүгнэн үнэлдэг. Үнэлэхдээ үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон үр дүнг голчилдог. Энэ нь ч маш чухал юм учир нь эко зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, сайжруулахад. МБОК-ын зүгээс бидний ажил байдалтай энэ жилийн хувьд 4-5 удаа хяналт, үнэлгээ өгч ажилласан. Ингэсний үр дүнд манай эко зөвлөлийн үйл ажиллагаа идэвхижиж байгаа.

#### **Тавдугаар алхам: Шинэ техник технологи ашиглан сургалт зохион байгуулах**

БОБ олгох сургалтыг мэдээллийн санг ашиглан “Иргэний боловсрол “хичээлээр хуваарийн дагуу тогтмол орж хэвшсэн үүний үр дүнд иргэний боловсрол хичээлийг багш нар маш өндөр түвшинд заах чадвартай болсон ба сурагчид өөрийн хэмжээнд байгаль хамгаалах дадал чадвар эзэмшсэн. Жил бүр багш нарын баяраар уламжлал болгон иргэний боловсрол хичээлийг хэн сайн заах вэ уралдааныг зохион байгуулан 1,2,3-р байрт орсон хичээлийг Дөргөн ТҮ орон нутгийн телевизийн сувгаар цацдаг. Мэдээллийн төв нь сум, сургууль, орон нутгийн нийт ард иргэдийг мэдээлэл, болон гарын авлага, ном сурах бичиг бусад зүйлээр хангах зорилготой үйл ажиллагааг явуулсаар ирсэн. Энэ хугацаанд тус төв нь 43 нэр төрөл бүхий 97 ширхэг ном сурах бичигтэй болсон. 44 багш 615 сурагч 17 ажилчин тогтмол үйлчлүүлж , 57 эцэг эх ном сурах бичиг авч ашигласан, болон мод зүлэг шилжүүлэн суулгах ,дэцэг тарих зөвлөгөө авсан байна. Төслөөс манай сургуулийн эко мэдээллийн төвд иж бүрэн компьютер, принтер, сурталчилгааны самбар, ном сурах бичиг гарын авлагаар хангаж өгсөн байгаа.

#### **Зургаадугаар алхам: Орон нутгийн байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх**

Сургалтын таатай орчин бий болгох зорилгоор уламжлал болгон байгальд ээлтэй анги шалгаруулдаг. Манай сургууль сургалтыг 2 сард нэг удаа Дөргөн TV орон нутгийн телевизийн сувгаар явуулдаг нь сумын нийт ард иргэд тус бүрд хүрдэг онцлогтой.

#### **Долдугаар алхам: Байгальд ээлтэй сургууль болох зорилтыг хэрэгжүүлэх талаар бүх талын үйл ажиллагааг идэвхжүүлэх**

**Эко код лого, уриа:** Уриа: Манай сургууль нь “Байгаль эхээ унаган төрхөөр нь хайрлая” гэсэн уриатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**3. Тэргүүн туршлага:** 2004 оноос эхлэн “Ногоон сургууль” “Байгальд ээлтэй сургууль” болох зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд нутгийнхаа элсний нүүдэл цөлжилт зэргийг тогтоон барьж байдаг буглаг ургамал болох харгана, шаваг, тэсгэн, бударгана, гэх мэтийн ургамалууд манай нутагт элбэг ургадаг. Харамсалтай нь нутгийн иргэдийн ухамсаргүй байдлаас болж түлшний хэрэглээнд зүй бусаар ашигласны улмаас элсний нүүдэл цөлжилт жил ирэх тусам ихэссээр байна. Иймээс энэ байдлыг бага боловч зогсоох өөрсдийн хувь нэмрийг оруулахын тулд манай сургуулийн хамт олон зуны даалгаварт сурагчдаас (1өрхөөс) аргал түүлгэж, дотуур байрныхаа хэрэгцээнд хэрэглэдэг болсон . Тус сургуульд дундажаар 380 гаруй өрхийн

сурагчид сурдаг. 1өрх -2 уут аргал =760уут буюу 3-4 машин аргал цуглардаг. 1 машин аргал илчлэг чанарынхаа хувьд 2 машин харгана,шавагтай тэнцэнэ.

Сүүлийн 5 жилээр тооцвол 10 машин бутлаг ургамлыг хамгаалж элсний нүүдлээс тодорхой хэмжээгээр нутгаа хамгаалж байна.